

## ЭХ ХЭЛНИЙ ТУЛГАМДСАН АСУУДАЛД

*Л. Батчулуун*

*Ахмад, ахлах багш*

*Хууль сахиулахын их сургууль. Эрх зүй, нийгмийн ухааны сургууль*

*batchuluun@leu.gov.mn*

**Хураангуй:** Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн.<sup>48</sup> хэмээн Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.1.6 дахь хэсэгт заажээ. Хил, хэл мал гуравтайгаа байхад хэн баян? Монгол баян. Хил, хэл, мал гурваасаа салбал хэн эмгэнэлтэй? Монгол эмгэнэлтэй хэмээн төрийн соёрхолт, яруу найрагч, сэтгүүлч З.Дорж нэгэнтээ хэлсэн байдаг. Орчин цагийн хүүхэд, залуусын эх хэлний боловсрол, эх хэлээрээ ярьж, бичих чадвар, түүнийг хайрлан хамгаалах, тээн хөгжүүлэх ухамсар зохих түвшинд багаа эсэх нь эргэлзээтэй байна. Үүнд нөлөөлж буй олон хүчин зүйл байгаа бөгөөд эх хэлээ цэвэр ариун байлгах, эзэн нь юм шиг эзэмшихэд хувь хүн, гэр бүл, шат шатны боловсролын байгууллага, төр засаг бүгд санаа тавих үүрэгтэй юм.

**Түлхүүр үг:** Хэл, өв соёл, монгол хэлний дархлаа, даяарчлал, интернэт

**Судалгааны зорилго:**

Эх хэлний хөгжилд гадаад хэл, интернэт орчин, иргэдийн үүрэг хариуцлагаа ухамсарлаагүй байдал хэрхэн сөргөөр нөлөөлж буйг судалж энэхүү байдлыг засан залруулах боломжийг эрэлхийлэхэд ошино.  
**Судлагдсан байдал:**

Доктор, профессор С.Дулам, Ц.Өнөрбаян, Н.Баянсан, Ч.Жачин, Д.Заяабаатар, Ш.Баттөгс, О.Самбуудорж, Ж.Бат-Ирээдүй, М.Саруул-Эрдэнэ, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Д.Боролзой, Н.Мөнхцэцэг нарын эрдэмтэд судалгааны өгүүлэл, бүтээлүүддээ хөндсөн байна.

**Судалгааны арга:**

Баримтын болон тоон судалгаа, мэдээлэл цуглуулах аргыг ашигласан болно.

**Оршил**

Эдүгээ дэлхийд 6000-7000 орчим хэлээр хүмүүс хоорондоо ярьж байгаа ч зуугаад жилийн дараа 90-95 хувь нь мөхнө гэж эрдэмтэд үздэг. Дэлхийн түүхнээ олон хэл үүсч мөхөж байсан боловч орчин цагт хэлний хэрэглээнээс гарах, улмаар мөхөж сөнөх үйл явц нийгэм, эдийн засгийн олон шалтгаанаар улам хурдасч байна.

---

<sup>48</sup> Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал

Эдийн засгийн хүчтэй хэлнүүд бусдыгаа "ноёрхож, эрхшээлдээ оруулах" процесс дэлхийн дахинаа өрнөж байна.

Дюссельдорфийн Их Сургуулийн эрдэмтэд 15 жилийн турш хийсэн судалгааны үр дүнгээ танилцуулжээ. Тэд дэлхийн хүмүүсийн ярьдаг 7102 өөр хэлнүүдийн талаар сонирхолтой тоон баримт дурьдсан байна. Судлаачдын үзэж буйгаар манай гарагийн хүмүүс 7102 өөр хэлээр ярьдаг гэнэ. Шинжээчдийн гаргасан тоогоор Азид амьдардаг хүмүүс хамгийн олон буюу 2301 хэлээр ярьдаг бол Европын бүс нутагт амьдардаг хүмүүс 286 өөр төрлийн хэлээр ойлголцдог аж.

Тэгвэл манай гараг дээр унаган хятад, хинду, англи хэлтэй хүн хамгийн олон байдаг. Мөн дэлхийн нийт хүн амын гуравны хоёр нь өргөн тархсан 12 хэлээр ярьж байна гэжээ.



Дэлхий нийт даяарчлагдаж байгаатай холбоотойгоор зарим хэл, соёл хүчээ авч шинээр суралцаж буй хүний тоо ч өсөн нэмэгдэж байгаа юм. Одоогоор дэлхийн 1.5 тэрбум хүн англи хэлийг эрчимтэй судалж байгаа аж. Мөн франц, испани, итали, хятад, япон, герман хэл сурч буй хүмүүсийн тоо нэмэгдсээр байна.<sup>49</sup>



### Үндсэн хэсэг

Зарим хэл, соёл хүчээ авч шинээр суралцах хүмүүсийн тоо өсөн нэмэгдэж байхад зарим хэлээр ярилцагчийн тоо өдөр ирэх тусам улам буурсаар байна. Тэгвэл мөхсөн хэл гэж ямар хэлийг хэлэх вэ?

**Мөхсөн хэл** : Ард түмэн ярихгүй, хэрэглэхгүй болсон хэл<sup>50</sup> гэжээ. Монголчууд бид эх хэлээрээ хэрхэн ярьж, хэрэглэж байгаа билээ гэдгийг бодох цаг болжээ.

Эх хэлний аюулгүй байдалд нөлөөлж буй хүчин зүйлүүд

1. Гадаад хэлний нөлөө

<sup>49</sup> <http://old.eagle.mn>

<sup>50</sup> Монгол хэлний их тайлбар толь

АНУ-ын судлаач Гита Стейнэр Хамси Монголын талаарх судалгааны бүтээлдээ “Монгол улс манжийн дарлалд 220 жил болохдоо хэл бичгээ сайтар хамгаалж үлдсэн ч ардын хувьсгалаас хойш маш богино хугацаанд бүрэн оросжсон улс болж хувирсан” гэсэн байдаг. Ардын хувьсгал ялснаас хойш орос хэл Монгол улсад түгэн дэлгэрээд 80 гаруй жил болсон. ЗХУ задран унасны дараа буюу 1999 оноос хойш бүх шатны сургуульд заах орос хэлний сургалтын цаг, орос хэл сурах хүний тоо цөөрч улмаар хүн бүр англи хэл сурах давлагаанд өртсөн.<sup>51</sup>

а) Даяаршил гэдэг нь дэлхийн улс орнууд эдийн засаг, санхүү, улс төр, хэл, соёл, техник, технологи, цэргийн салбарын хүрээнд нэгдэн нягтрах үйл явц юм. Даяаршлын эрин үед нийгмийн хэрэгцээ шаардлагаас шалтгаалан эцэг эхчүүд үр хүүхэддээ багаас нь гадаад хэл эзэмшүүлэх болсон. 2018 оны байдлаар Монгол улсын хэмжээнд ерөнхий боловсролын 798 сургууль сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаагийн 652 буюу 81.7 хувь нь төрийн өмчийн, 146 буюу 18.3 хувь нь хувийн өмчийн сургууль байна.<sup>52</sup> Хувийн өмчийн сургууль дотроо 18 нь буюу 12.8 хувь нь бага сургууль байна гэсэн статистик гарчээ.

2017-2018 оны хичээлийн жилд хувийн өмчийн бага сургуульд 3826 сурагч нэгдүгээр ангид элссэн байна. Эдгээр хувийн өмчийн сургуулиуд математик, гадаад хэлний хичээлийг 1 дүгээр ангиас нь гүнзгийрүүлэн судалдаг. Энэ нь төрийн өмчийн сургуулийн тоотой харьцуулахад бага мэт санагдавч жил бүр өдий тооны хүүхэд гадаад хэлээр бага боловсрол эзэмшихээр болж байна. Мөн гадаад хэлний сургалттай цэцэрлэгүүд олноор бий болсон.

б) Нийгэм, эдийн засгийн тогтворгүй байдал, ажилгүйдэл, ажлын байрны хомсдол, цалин хөлс бага амжиргаанд нь хүрдэггүй зэргээс шалтгаалан ихэнх залуус ажил хөдөлмөр эрхлэх, сурч боловсрохоор гадны улсыг зорих болсон. 2019 оны байдлаар Монгол улсын 130.000 гаруй иргэн гадаадад сурч, ажиллаж амьдрахаас гадна гадаадын иргэнтэй гэр бүл болох, иргэншлээ сольсон иргэдийн тоо жилээс жилд өссөн үзүүлэлттэй байна. Үүнийг дагаад гадаадад төрж өссөн хүүхдүүд харь хэлээр хэлд орж харь хэлээр боловсрол эзэмших болсон.

Гадаад хэлийг хүүхдэд хэдэн наснаас нь заах хэрэгтэй вэ? Хүүхдийн аливаа хэлийг эзэмших биологийн идэвхтэй нас нь 0-10 гэж эрдэмтэд тодорхойлсон байдаг.

- 0-5 нас энэ насныхан аливааг шууд бодитоор хүлээж авдаг. Хийсвэр сэтгэлгээ арай хөгжиж амжаагүй байдаг нь хэл сурахад маш том давуу тал болдог. Авиа таних, ажиглах чадвар бусад

---

<sup>51</sup>“ XX зуунд ЗХУ-аас Монгол улсад үзүүлсэн нөлөө” өгүүлэл

<sup>52</sup> Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

насныхнаас 10 дахин өндөр байдаг тул хэл сурахдаа мастерууд гэж хэлж болно.

- 6-10 нас хүүхдийн сэтгэхүй бодит сэтгэлгээнээс логик буюу хийсвэр сэтгэлгээ рүү шилжих эхний үе гэж үздэг. Энэ үед хүүхдүүдийн баруун тархи маш давамгай ажилладаг, төсөөлөн бодох чадвар маш сайн, аливаа хэлний системийг бүхлээр нь хүлээж авдаг. Энэ насан дээр англи хэлийг сурвал авиа зүй, дуудлага, сэтгэхүй зэргийн суурь сайн тавигддаг.<sup>53</sup> Энэ үеэс хойш гадаад хэлийг эх хэл шигээ эзэмшиж чаддаггүй гэж үздэг.

Гадаад хэлийг бага насанд нь эзэмшүүлэхэд эх хэл шигээ сурах сайн талтай хэдий ч эргээд маш олон сөрөг үр дагавар дагуулдаг. Хэл бол сэтгэхүйн эрхтэн. Хүн анх ямар хэл сурна тухайн хэлээр сэтгэдэг. Хүний тархи хоёр хэл дээр зэрэг сэтгэнэ гэж байхгүй, хэрэв тэгж чадаж байвал тэр хоёрын аль нэг нь заавал оновчтой байна. Монголоороо сайн ярьж сураагүй хүүхдэд гадаад хэл заах нь гадаад ч үгүй монгол ч үгүй заримдаг болгож сэтгэлгээ саатдаг.

Одоогийн их, дээд сургуульд суралцаж буй залуусын тодорхой хувь нь бага насандаа эцэг, эхээ дагаж гадаадад амьдарч тухайн улсын бага, дунд сургуульд суралцаж гадаад хэлийг эх хэлээсээ илүү эзэмшсэн байдал харагддаг. Хичээл зааж байх явцад зарим оюутнууд наад захын монгол үг хэллэгийг ойлгохгүй монгол хөрсөнд буулгаж чадахгүй монгол хэлээр аялгатай ярих, зөв бичгийн дүрмийн алдаатай бичих үзэгдэл цөөнгүй ажиглагддаг.

Нөгөөтэйгүүр хэл бүр өөрийн ахуй амьдрал, түүх, соёлыг илэрхийлдэг. Гадаад хэлийг сурч эхлэхээр тэр хүний сэтгэлгээ тухайн орны соёл, ёс заншилд нь дуртай болж эхэлдэг. Бид үр хүүхэддээ бага наснаас нь гадаад хэлийг сургаснаар гадны нэг иргэн бэлгэж байгаагаас ялгаагүй болж байна.

с) Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд гадаад болон монгол хэлийг хэдэн цагийн багтаамжтай зааж байна вэ?

---

<sup>53</sup> <https://www.unread.today/>

Ерөнхий боловсролын сургуулийн дунд  
ангийн сургалтын шинэчилсэн төлөвлөгөө <sup>54</sup>

Боловсрол, соёл, шинэлэх ухааны сайдын  
2015 оны 06 дугаар сарын 17 өдрийн  
дугаар тушаалын хавсралт

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ДУНД АНГИЙН СУРГАЛТЫН ШИНЭЧИЛСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д.д	Хичээл, судлагдахуун	VI анги	VII анги	VIII анги	IX анги	Дүн
1	Монгол хэл, бичиг	105	70	70	70	315
	Уран зохиол	70	70	70	70	280
	Үндэсний бичиг	70 <sup>3</sup>	70	70	70	280
2	Математик	175	140	140	140	595
3	Мэдээллийн технологи	35	35	35	35	140
	Физик	35	70	70	70	245
4	Байгалийн ухаан	35	70	70	70	245
	Хими	35	70	70	70	245
	Газар зүй		35	35	35	105
5	Нийгмийн ухаан	35	70	70	70	245
	Нийгэм судлал		35	35	35	105
6	Урлаг	35	35	35	35	140
	Дурслэх урлаг		35	35	35	105
7	Дизайн технологи	70	70	70	70	280
	Технологи		70	70	70	210
8	Биеийн тамир, эрүүл мэнд	70	70	70	70	280
9	Гадаад хэл	105	105	105	105	420
	Англи хэл		70	70	70	210
	Орос хэл		70	70	70	210
	<b>Дүн</b>	<b>910</b>	<b>1120</b>	<b>1120</b>	<b>1120</b>	<b>4270</b>

Ерөнхий боловсролын сургуулийн ахлах  
ангийн сургалтын төлөвлөгөө

Боловсрол, соёл, шинэлэх ухаан, спортын  
сайдын 2017 оны 11 дугаар сарын 14 өдрийн  
дугаар тушаалын хавсралт

**Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сургалтын төлөвлөгөө**

Хичээл		X анги	XI анги	XII анги
<b>1. Заавал судлах</b>				
1	Монгол хэл, бичиг	105	70	70
2	Уран зохиол	35	35	35
3	Математик	105	105	105
4	Физик	70	70	70
5	Хими	70	70	70
6	Биологи	70	70	70
7	Газар зүй	70	70	70
8	Монголын түүх	35	35	35
9	Нийгэм судлал	70	70	70
10	Англи хэл/Орос хэл	105	105	105
11	Биеийн тамир, эрүүл мэнд	70	70	70
12	Дизайн/зураг зүй, технологи	70	70	70
13	Мэдээллийн технологи	35	35	35
Заавал судлах нийт цаг		910	875	875

Дээрх сургалтын төлөвлөгөөнөөс харахад гадаад хэлний цаг харьцангуй их байна.

Анхаарах асуудал:

✚ Бага насны хүүхдийг хамгийн түрүүнд эх хэлээрээ зөв сайхан унших, бичих, ярих, сэтгэх чадварт сургаж, эх оронч үзлээр хүмүүжүүлэх

<sup>54</sup> Суурь оловсролын сургалтын цөм хөтөлбөр БСШУЯ УБ., 2015

үүнд төр засаг гэхээсээ илүү эцэг, эхийн оролцоо чухал гэдгийг ухамсарлах.

✚ Гадаад хэлний сургалттай цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаанд хяналт тавих, тоог цөөлөх

✚ Хилийн чанадад байгуулагдсан монгол сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа, монгол иргэдийн санаачлагаар байгуулагдсан төрийн бус байгууллагад дэмжлэг үзүүлэх ажлыг эрчимжүүлэх, бүх талаар нь дэмжих /жишиг хөтөлбөр, электрон сурах бичиг/

✚ Ард иргэдээ нийгмийн баталгаатай, эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлөөр хангаж харьд одсон монголчуудын цувааг эргүүлэх.

✚ Ерөнхий боловсролын сургуульд зааж буй монгол хэлний хичээлийн цагийг нэмэгдүүлэх

## 2. Интернет орчин

Социализмын үе буюу 1990 оноос өмнө одоогийнх шиг олон хэвлэл мэдээллийн хэрэгсэл байгаагүй хяналт тавихад цомхон байсан учир тухайн үед зөв бичгийн дүрмийн болон найруулгын алдаа мадаг гарах нь бага мөн дунд сургуулийн монгол хэлний хичээлээр зөв бичих дүрэм голлон заадаг байсан.

Телевиз, сонин сэтгүүлээр алдаатай үг, өгүүлбэр нийтэлбэл эвэртэй туулай үзсэн мэт байдаг байлаа.

Монгол улс анх 1996 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр интернэтэд холбогдож тухайн үед 500 гаруй хэрэглэгчтэй байсан бол 2019 оны байдлаар энэ тоо 2.910.000 хүрээд байна.<sup>55</sup> Интернет орчин нь мэдээллийн түргэн шуурхай, хүчтэй хэрэгсэл болохын хувьд иргэдийн эх хэлний боловсролд үзүүлж буй нөлөө асар их юм. Монгол хэлний тухай хуулийн 20.2.1 дэх хэсэгт Монгол улсын иргэн монгол хэлний хэм хэмжээг дагаж мөрдөнө<sup>56</sup>. хэмээн заасан байна. /зөв бичих, зөв дуудах, хэлзүйн, утга зүй, үгийн сангийн хэм хэмжээ/ Гэтэл бид интернэт /facebook, tweeter, Blog/ ашиглахдаа энэхүү хэм хэмжээг гажуудуулж түүнийгээ өөрөө ч мэдэхгүй суух нь элбэг болжээ. Орчин цагийн утга зохиолын хэл нь ярианы болон бичгийн хэл гэсэн хоёр төрөлтэй атал цахим орчинд мэдээллийг түргэн шуурхай авах, түгээх, хурдан бичих, өвөрмөц харагдах, яриагаа хэмнэх, ярьж байгаа мэт бичих зэрэг хэрэгцээнээс үүдэлтэйгээр ярьж, хэлж байгаагаа бичигт тэр чигээр нь буулгаж ярианы хэлийг бичгийн хэлтэй хольж хутгах болсон.

Жишээ нь: Болийшдээ- болно ш дээ, байжийгаад- байж байгаад , байгаа шд- байгаа шүү дээ, болуу-болов уу, мээн-минь, заржийгаа-зарж

---

<sup>55</sup> Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

<sup>56</sup> Монгол хэлний тухай хууль 2015 он

байгаа, явжийтал-явж байтал, байгаамдаа-байгаа юм даа, шидчүүл-шидчихвэл, тэгдийнбэ-тэгдэг юм бэ гэх мэт.

Иймэрхүү байдлаар ярианы хэл бичгийн хэлийг хольж бичээд байвал зөв бичгийн дүрэм хэрэггүй мэт. “Худал үгийг мянган удаа давтвал үнэн болдог” гэдэг үг байдаг. Асар их хэрэглэгчтэй мэдээллийн энэ хэрэгслээр зөв бичгийн дүрмийн алдаатай, буруу, зөрүү бичээд байвал энэ нь аажимдаа хүний нүдэнд дасал болж эргээд засахад ихээхэн хүндрэл учруулна.

Харь хэлнээс үг авч монгол хэлний үгийн санг баяжуулах арга монгол хэлэнд байдаг энэ нь хэвийн зүйл боловч цахим орчинд гадаад, монгол үгээр хольж бичих орчуулан хэрэглэж болохоор гадаад үгийг тэр чигээр нь хэрэглэж хэлийг гажуудуулах явдал түгээмэл болсон.

Жишээ нь: уба, ёбуу /солонгос/, ваав, ваав л даа, лайк, коммент, сээвлэх, сийндэх, копидох, мэйлдэх сэлфидэх, порматлах, катлах, дэлэтлэх гэм мэт.

Аливаа зүйл сайн муу хоёр талтай дээрх жишээний адил интернэт нь эх хэлний боловсролд сөргөөр нөлөөлөх боловч сайн тал нь гэвэл бид дэлхий ертөнцтэй хөл нийлүүлэн алхаж, мэдээллийг түргэн шуурхай цаг алдалгүй авахын зэрэгцээ мөнгө, санхүү, цаг заваа ч хэмнэж байгаа. Олон мянган хэрэглэгчтэй мэдээллийн энэ сүлжээг эх хэлний боловсролд муугаар биш харин сайнаар нөлөөлөхөд нь ашиглах хэрэгтэй юм.

Анхаарах асуудал:

✚ Цахим очинд зөв бичгийн дүрэм, найруулгын алдаагүй харилцаж сурахад олон нийтийг уриалах

✚ Монгол хэлний хэм хэмжээг зөрчсөн буруу зөрүү бичиж найруулахад шүүмжлэлтэй хандаж засан залруулахад хүн бүр идэвхтэй оролцох.

✚ Монгол хэлний зөв бичгийн журмалсан толийг албан хэрэгцээндээ ашиглаж хэвших

✚ Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн орчинд ухаалаг утас хэрэглэхгүй байх засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх явцад багш, эцэг эх анхаарлаа хандуулах

3. Үүрэг, хариуцлага

2015 оны 02 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан Монгол хэлний тухай хуульд:<sup>57</sup>

6.1.7. Газар нутаг, засаг захиргааны нэгж, гудамж, зам, талбай, хуулийн этгээдийн нэр, хаяг;

---

<sup>57</sup> Монгол хэлний тухай хууль 2015 он

6.1.11. Албан байгууллага, барилга, байгууламж, нийтийн тээврийн хэрэгсэлд байрлуулах зааварчилгаа, мэдээлэл, аюулгүй ажиллагааны санамж.

8.1. Монгол улсын хэмжээнд кирил болон үндэсний бичгийн зөв бичих тус тусын нэгдмэл дүрэмтэй байх бөгөөд иргэн, хуулийн этгээд уг дүрмийг дагаж мөрдөнө.

15.1.1. Цахим орчинд монгол хэл, бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх

19.1.1. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хэвлэн нийтлэх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага монгол хэлний зөв бичих дүрэм, орчин цагийн утга зохиолын монгол хэлний хэм хэмжээг чанд баримтлах;

20.2.1. Монгол Улсын иргэн монгол хэлний хэм хэмжээг дагаж мөрдөх;

Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд

1.1.6. Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн.

3.1.3.2. Гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа иргэддээ эх орондоо эргэн ирж ажиллаж, амьдрах таатай нөхцөл, боломжийг бүрдүүлнэ.

3.1.3.3. Гадаадад төрж тухайн улсын иргэний харьяалалтай болсон иргэд, тэдний үр хүүхдэд Монгол Улсад зорчих, оршин суух, суралцах, ажиллаж амьдрах, даатгалд хамрагдах таатай нөхцөлийг бүрдүүлнэ. Хоёрдмол харьяалал үүсч, төрөөс иргэдийн ашиг сонирхлыг хамгаалах баталгаа алдагдахаас сэргийлнэ.

Хүүхдийн эрхийн тухайн конвенц

28 дугаар зүйл (с) эцэг эх, соёл, хэл, үнэт зүйлс, амьдарч байгаа улсынхаа болон төрсөн улс орныхоо үндэсний үнэт зүйлс болон өөрийнхөөсөө ялгаатай соёл иргэншлийг хүндэтгэх үзлийг төлөвшүүлэн хөгжүүлэх;

Дээрх хууль эрх зүйн актад туссан заалтууд бүгд эх хэл бичгээ эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэхтэй холбоотой бөгөөд хувь хүн, иргэнээс эхлээд шат шатны боловсролын байгууллага, төр засаг, монгол улсад ажиллаж амьдарч буй бүх хүнд хамаатай юм. Эдгээр заалтууд бодит байдал дээр хэрэгжихгүй цаасан дээр буусан төдий байгаа тул онцлон дурдсан болно.

## **ДҮГНЭЛТ**

Аливаа үндэстний дархлааг хадгалдаг гол хүчин зүйл нь хэл соёл юм. Хэл мөхнө гэдэг нь соёл, сэтгэлгээ түүх мөхнө гэсэн үг. Хэл соёлоо цэвэр ариунаар байлгах, харь хэлний нөлөөнд автуулахгүй байх, дархлааг нь

хадгалж үлдэх эсэх монголчуудаас өөрсдөөс нь шалтгаалах юм. Харь хэлийг сурч дэлхий нийттэй хөл нийлүүлэн алхах нь ирээдүйн Монгол улсын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулах хэдий ч хүүхдэд бага наснаас нь гадаад хэл зааснаар монгол ахуй, соёлоос хөндийрч сэтгэлгээ нь саармагжих аюултай.

Цахим орчинд харилцахдаа монгол хэлний хэм хэмжээг гажуудуулалгүй зөв бичиж найруулахад хүн бүр анхаарч буруу зөрүү бичсэн зүйлд шүүмжлэлтэй хандаж, ярихдаа ярианы хэлээр бичихдээ бичгийн хэлээр харилцаж интернетийг эх хэлээ мөхөөх биш хөгжүүлэх хэрэгсэл болгохыг уриалж байна.

Монгол улсын хууль, эрх зүйн актад туссан эх хэлээ эзэмших, хэрэглэх, хамгаалах, тээн хөгжүүлэхэд чиглэсэн заалтуудыг амьдрал дээр бодитой хэрэгжүүлэх нь бидний үүрэг гэдгийг ухамсарлацгаая.

Хэл бол ард түмэн юм оюун санааны баялаг юм. Хэрэв төрөлх хэлээ эзэмшээгүй, түүний гоо сайхныг мэдрээгүй бол бусад улсын хэлний эрдэнэсийн санд нэвтрэхийн аргагүй юм. /В.А. Сухомлинский/

## **НОМ ЗҮЙ**

[1] Монгол улсын үндсэн хууль УБ., 1992

[2] Монгол хэлний тухай хууль УБ., 2015

[3] Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал УБ., 2010

[4] Хүүхдийн эрхийн тухай конвенц

[5] Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр БСШУЯ УБ., 2015

[6] Статистикийн мэдээллийн нэгдсэн сан УБ., 2019

[7] Шинжлэх ухааны академи хэл зохиолын хүрээлэн “Эх хэлний боловсролын асуудалд” УБ., 2017

[8] Батсайхан Б., Дэлгэржав М. Ерөнхий сэтгэл судлал УБ., 2013

[9] Амарсанаа Ц., Мөнх-Эрдэнэ Б., Түвшинжаргал М., Чинбат Г. Үгээр урлахуйн ухаан УБ., 2011

[10] Шагдарсүрэн Ц., “Эх хэлээ эвдэхгүй юмсан” УБ., 2007

[11] <http://old.eagle.mn>

[12] <https://www.unread.today/>